




I-VI/2021

Тархаасан: 2021 оны 8 дугаар сарын 17



Нэг ажиллагчид ногдох ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2021 оны 2-р улиралд 6.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.5 (7.9%) сая төгрөгөөр өссөн байна.

Зураг 1. Нэг ажиллагчид ногдох ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, улирлаар, сая төгрөгөөр



Зураг 2. Нэг ажиллагчид ногдох ДНБ, салбараар, жил бүрийн 2-р улиралд, сая төгрөгөөр

Ерөнхий 4 салбараар авч үзвэл, 2021 оны 2-р улиралд өмнөх оны мөн үеэс уул уурхай, олборлолтын салбарын нэг ажиллагчид ногдох ДНБ буюу хөдөлмөрийн бүтээмж 12.7 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.7 (5.5%) сая төгрөгөөр, үйлчилгээнийх 4.7 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.8 (21.1%) сая төгрөгөөр нэмэгдсэн бол хөдөө аж ахуйн салбарынх 6.0 сая төгрөг болж, 0.8 (11.6%) сая төгрөгөөр, аж үйлдвэр, барилгын салбарынх 3.6 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.4 (10.4%) сая төгрөгөөр буурчээ.



Ойлголт, тодорхойлолт:

Бүтээмж нь улс оронд бий болсон үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийн үзүүлэлт бөгөөд үйлдвэрлэл (гарц), орцын харьцаагаар тодорхойлно. Хөдөлмөрийн бүтээмж нь нэг ажиллагчид ногдох бодит ДНБ-ээр хэмжигдэнэ. Хөдөлмөрийн бүтээмжийн тооцоонд ашиглаж буй ДНБ-д өөрийн эзэмшлийн орон сууцны хийсвэр түрээсийг тусгаагүй болно.

Тооцох аргачлал:

Нэг ажиллагчид ногдох ДНБ (нэмэгдэл өртөг)-ийг ДНБ (нэмэгдэл өртөг)-ий хэмжээг ажиллагчдын тоонд хувааж тооцно.

$$P = \frac{Q}{L}$$

P – хөдөлмөрийн бүтээмж

Q – дотоодын нийт бүтээгдэхүүн (нэмэгдэл өртөг)

L – ажиллагчдын тоо

Тайлбар:

Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А-09/08 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал"-ыг 2019 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөж байна.



Эх үүсвэр: ҮСХ

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 11 дүгээр сарын 17

Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны газрын
Үндэсний тооцооны алба
Утас : (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212